



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

199 9оны 7р сарын 22 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Суралцуулах тухай

Тушаах нь :

1. АНУ-ын Индиана мужийн Пүрдүгийн их сургуулийн докторантурт Техникийн их сургуулийн дэд захирал Банзар овогтой Пүрэв-Очирыг боловсролын эдийн засгийн мэргэжлээр, мөн сургуулийн магистрантурт МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан Жүгдэрсүрэн овогтой Баттогтохыг физикийн мэргэжлээр Гэгээрлийн яамны нэр дээр тус тус суралцуулсугай .

2. Б.Пүрэв-Очир, Ж.Баттогтох нартай гэрээ байгуулан холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан / Б.Ганбат/ -д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / С.Алтангэрэл/ - д тус тус даалгасугай .



Гэгээрлийн сайд

А.Баттөр